



**“НИЙСЛЭЛ АУДИТ” ХХК**

# **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“ГУТАЛ” ХК**

2020 оны 12 сарын 31-нээрх тасалбар болгосон  
санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

Компанийн мэдээлэл .....	2
Удирдлагын батламж мэдэгдэл .....	3
Хараат бус аудиторын дүгнэлт .....	4-5
Аудитлагдсан санхүүгийн тайлан .....	6
<i>Орлого, Үр дүнгийн тайлан</i> .....	6
<i>Санхүү байдлын тайлан</i> .....	7
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i> .....	8
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i> .....	9-10
Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11-30

**КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

---

**АЛБАН ХАЯГ:**

Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 2-р хороо,  
Чингисийн өргөн чөлөө, Гутал ХК

Утас: +976-11341579

Э-хаяг: [www.gutalco.mn](http://www.gutalco.mn)

Э-шуудан: [gutalzahirgaa@gmail.com](mailto:gutalzahirgaa@gmail.com)

---

**УДИРДЛАГЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

Ерөнхий захирал Ц.Төмөр

Ерөнхий нягтлан бодогч Г.Энхриймаа

---

**ХАРААТ БУС АУДИТОР**

“Нийслэл-Аудит” ХХК-ийн аудиторууд

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
6-р хороо, Бага тойруу – 44 байр, 1 тоот  
Утас: +976-11-318918; +976-7012-0095

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

“Гутал” ХК-ийн (цаашид “Компани” гэх) Ерөнхий захирал Ц.Төмөр болон Ерөнхий нягтлан бодогч Л.Өнөрсайхан бид энэхүү тайлангийн 4-28 дүгээр хуудсанд толилуулсан санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Ц.ТӨМӨР  
(Ерөнхий захирал)

Г.ЭНХРИЙМАА  
(Ерөнхий нягтлан бодогч)

Огноо: 2021.03.09

Улаанбаатар хот



# “НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “ГУТАЛ” ХК-ИЙН УДИРДЛАГАД

Бид танай байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан хаалтын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

#### *Зорчилгүй дүгнэлт*

Танай байгууллага 2020 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв.

Уг стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн “Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага” хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлсэн билээ.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

#### *Аудитын гол асуудлууд*

Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

#### *Бусад мэдээлэл*

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

#### *Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг*

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын холбогдох олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын хүлээх үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана. Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

**Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм.

Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв. Аудит хийхдээ аудитын горим (Шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болголт, тулгах гэх мэт)-уудыг ашиглав.

Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

**Тайлангийн зориулалт**

Энэхүү тайланг танай байгууллагын хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэв. Бид энэ тайлангийн агуулгын хүрээнд гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Аудиталсан санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав.



*[Handwritten signature]* — Т.СУГАРСҮРЭН

2021 оны 03 сарын 09 өдөр

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“ГУТАЛ” ХК-ИЙН 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН  
ЖИЛИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Тодруулга	2019.12.31	2020.12.31
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	4	18,181.8	-
Борлуулалтын өртөг	5	-	-
<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>18,181.8</b>	-
Түрээсийн орлого		4,122,721.2	3,672,469.6
Хүүний орлого	6	292,660.6	73,408.7
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого		32,385.9	2,428.6
Борлуулалт, маркетингийн зардал			
Ерөнхий ба удирдлагын зардал	7	1,683,124.6	2,036,299.5
Санхүүгийн зардал			
Бусад зардал	9	110,776.4	7,415.1
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	8	14,107.3	67,849.6
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		(1.0)	(7.6)
Бусад ашиг (алдагдал)			
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>2,686,154.8</b>	<b>1,772,434.3</b>
Орлогын албан татварын зардал:	10	282,502.9	7,340.9
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>2,403,651.9</b>	<b>1,765,093.4</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг(алдагдал)		-	-
<b>Тайлант хугацааны цэвэр ашиг(алдагдал)</b>		<b>2,403,651.9</b>	<b>1,765,093.4</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
<b>Орлогын нийт дүн</b>		<b>2,403,651.9</b>	<b>1,765,093.4</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**“ГУТАЛ” ХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**“ГУТАЛ” ХХК-ИЙН 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Тодруулга	2019.12.31	2020.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		708,612.9	641,608.2
Дансны авлага	16	426,423.3	805,492.0
Татвар, НДШ-ийн авлага		12,444.4	40,806.2
Бусад авлага	17	2,138,085.9	1,420,072.5
Бусад санхүүгийн хөрөнгө		1,476,100.6	1,424,945.0
Бараа материал	15	114,355.9	112,976.4
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b><u>4,876,023.0</u></b>	<b><u>4,445,900.3</u></b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	11	8,130,509.0	7,943,582.8
Биет бус хөрөнгө	12	978.8	537.6
Урт хугацаат хөрөнгө оруулалт		25,216.6	25,216.6
Хойшлогдсон татварын хөрөнгө	14	-	353,304.2
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b><u>8,156,704.4</u></b>	<b><u>8,322,641.2</u></b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>		<b><u>13,032,727.4</u></b>	<b><u>12,768,541.5</u></b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны өглөг		-	4,800.0
Цалингийн өглөг	21	5,564.3	18,007.7
Татварын өр	22	125,307.9	35,056.5
Ногдол ашгийн өглөг		555,905.6	646,083.4
Урьдчилж орсон орлого		78,303.3	94,647.8
Бусад богино хугацаат өр төлбөр		17,269.0	17,529.3
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b><u>782,350.1</u></b>	<b><u>816,124.7</u></b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өр		27.5	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b><u>27.5</u></b>	<b><u>-</u></b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b><u>782,377.6</u></b>	<b><u>816,124.7</u></b>
<b>Эздийн өмч</b>			
Хувийн өмч	20	161,868.4	161,868.4
Халаасны хувьцаа		(13,823.9)	(13,823.9)
Нэмж төлөгдсөн капитал		90,744.7	90,744.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		8,364,780.0	8,364,780.0
Эздийн өмчийн бусад хэсэг		1,369.0	332,153.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		3,645,411.6	3,016,694.7
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b><u>12,250,349.8</u></b>	<b><u>11,952,416.9</u></b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>		<b><u>13,032,727.4</u></b>	<b><u>12,768,541.5</u></b>

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салцгүй хэсэг болно.*



“ГУТАЛ” ХК-ИЙН 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>161,868.4</b>	<b>(13,823.9)</b>	<b>90,735.8</b>	<b>8,455,805.3</b>	<b>1,369.0</b>	<b>2,515,436.5</b>	<b>11,120,365.8</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт							
Залруулсан үлдэгдэл	161,868.4	(13,823.9)	90,735.8	8,455,805.3	1,369.0	2,515,436.5	11,120,365.8
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						2,403,651.9	2,403,651.9
Бусад дэлгэрэнгүй орлого							
Өмчид гарсан өөрчлөлт			8.9			(49,894.0)	(49,885.1)
Зарласан ноогдол ашиг						(1,223,782.8)	(1,223,782.8)
Дахин үнэлгээний нэмэгдэл							
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>161,868.4</b>	<b>(13,823.9)</b>	<b>90,744.7</b>	<b>8,364,780.0</b>	<b>1,369.0</b>	<b>3,645,411.6</b>	<b>12,250,349.8</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт							
Залруулсан үлдэгдэл	161,868.4	(13,823.9)	90,744.7	8,364,780.0	1,369.0	3,645,411.6	12,250,349.8
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						1,765,093.4	1,765,093.4
Бусад дэлгэрэнгүй орлого							
Өмчид гарсан өөрчлөлт					330,784.0	204.9	330,988.9
Зарласан ноогдол ашиг						(2,394,015.2)	(2,394,015.2)
Дахин үнэлгээний нэмэгдэл							
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>161,868.4</b>	<b>(13,823.9)</b>	<b>90,744.7</b>	<b>8,364,780.0</b>	<b>332,153.0</b>	<b>3,016,694.7</b>	<b>11,952,416.9</b>

Хавсаргасан тодруулга энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**"ГУТАЛ" ХК-ИЙН 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН  
ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b><u>4,510,639.0</u></b>	<b><u>3,747,246.8</u></b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,471,424.8	3,744,817.3
Бусад мөнгөн орлого	39,214.2	2,249.4
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b><u>2,226,541.5</u></b>	<b><u>2,130,976.0</u></b>
Ажиллагчдад төлсөн	320,321.0	405,867.5
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	105,400.0	49,696.0
Бараа материал худалдан авахад төлсөн	683.6	21,355.0
Ашиглалтын зардалд төлсөн	520,053.3	317,953.8
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,175.8	4,700.0
Татварын байгууллагад төлсөн	857,411.3	639,166.8
Даатгалын нөхөн төлбөрт төлсөн	295.8	-
Бусад мөнгөн зарлага	412,200.7	692,236.9
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b><u>2,284,097.5</u></b>	<b><u>1,616,270.8</u></b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b><u>2,176,997.0</u></b>	<b><u>1,516,913.2</u></b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	20,000.0	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	53.5	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	19,087.3	11,297.3
Хүлээн авсан хүүний орлого	286,441.6	29,515.3
Хугацаатай хүүтэй хадгаламж	1,851,414.6	1,476,100.6
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b><u>4,151,295.0</u></b>	<b><u>3,233,980.2</u></b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	576,124.5	252,490.6
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,320.0	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	81.3	-
Хугацаатай хүүтэй хадгаламж	1,476,100.6	1,424,945.0
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	2,097,668.6	1,556,544.5
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b><u>(1,974,298.0)</u></b>	<b><u>(1,717,067.0)</u></b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b><u>1,945.2</u></b>	<b><u>65,062.4</u></b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,945.2	-
Бусад мөнгөн орлого	-	65,062.4
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b><u>460,334.1</u></b>	<b><u>31,270.9</u></b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	26,577.5	4,219.0
Төлсөн ноогдол ашиг	-433,756.6	26,783.9

“ГУТАЛ” ХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бусад зарлага		268.0
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-458,388.9</b>	<b>33,791.5</b>
Валютын ханшийн зөрүү	15,432.3	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-133,157.1	(67,004.7)
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>841,770.0</b>	<b>708,612.9</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>708,612.9</b>	<b>641,608.0</b>

*Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

“ГУТАЛ” ХХК-ИЙН 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР  
БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

“Гутал” ХК нь 1934 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Аж Үйлдвэрийн Комбинатын харьяанд гутлын фабрик нэртэйгээр үйлдвэрлэлээ эхэлсэн байна.

1990 онд ялсан ардчилсан хувьсгал иргэн бүрийг хувийн өмчтэй болгох зорилго тавьжээ. “Өмч хувьчлалын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээний үр дүнд Гутлын үйлдвэрийг БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 51 дугаар тогтоолоор хувьчлагдан 161 868,4 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй “Гутал” ХК болон болон байгуулагджээ. “Гутал” ХК нь тухайн үед 10 314 хувьцаа эзэмшигчидтэй, 161 868,4 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар төрөл бүрийн гутал, хэвлүүр, цавуу үйлдвэрлэж борлуулах, ажлын байрны түрээсийн үйл ажиллагаа эрхлэхээр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Тус компани нь тухайн үед нийт 1 618 684 ширхэг хувьцаа гаргасан байх бөгөөд 1992 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс 1992 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн хооронд нийтдээ 10 удаагийн арилжаагаар дээрхи хувьцааны 90 хувийг арилжжээ. Уг анхдагч зах зээлийн арилжааны дээд ханш 225 төгрөг доод ханш нь 26, дундаж ханш нь 48 төгрөг байсан байна. Одоогийн байдлаар “Гутал” ХК нь улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрэмд заасан дээрх үйл ажиллагаанаас зөвхөн гутлын хэвлүүр захиалгаар үйлдвэрлэх болон өөрийн компанийн байрыг түрээслэх үйл ажиллагаа явуулж байна.

“Гутал” ХК нь давуу эрхийн хувьцаа болон бусад төрлийн үнэт цаас гаргаагүй байна. Тус компани нь өөрийн хөрөнгөөр 1995 оноос хойш өөрийн компанийн хувьцааг худалдан авч байсан бөгөөд өнөөдрийн байдлаар 43,674 ширхэг халаасны хувьцаатай, эдгээр хувьцаа нь Компанийн тухай хуульд заасан саналын эрхгүй, ногдол ашиг авдаггүй байна.

## 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТУХАЙ

### *Санхүүгийн тайлангийн нийцэл*

Компани санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан СТОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

### *Тайлан бэлтгэсэн үндэслэл*

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйг Тэмдэглэл 3-т толилуулав. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай баримталж мөрдсөн болно.

Монгол улсын мөнгөн тэмдэгт болох төгрөг нь компанийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч үндсэн валют юм. Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнав.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэх зорилго нь байгууллагын хөрөнгө, эх үүсвэр, санхүүгийн байдлыг хүлээн зөвшөөрсөн орлого зарлага, тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээг СТОУС, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС)-уудын дагуу үнэн зөв илэрхийлэх явдал юм.

### *Тасралтгүй байх зарчим*

2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлан нь үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим дээр үндэслэгдсэн бөгөөд компанийн удирдлага нь үйл ажиллагаагаа цаашид тасралтгүй явуулахад аливаа макро болон микро орчны тодорхойгүй байдал, сөрөг нөлөөлөл байхгүй гэж үзсэн болно. Энэ нь санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэх үндэслэл болно.

### *Санхүүгийн хэрэглүүр ба түүний эрсдэл*

Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл үүсгэдэг дараах үндсэн санхүүгийн хэрэглүүрүүдийг компани хэрэглэдэг:

- Худалдааны болон бусад авлага
- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Бусад өглөг

Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангиллаас хамааран санхүүгийн хөрөнгүүдийг анхны өртгөөр, бодит үнэ цэнээр болон хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгана.

**Анхны өртөг** гэдэг нь худалдан авалтын өдөр төлөгдсөн мөнгөн хөрөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийн дүн, эсвэл хөрөнгө худалдаж авахад зориулагдсан бусад нөөцийн бодит үнэ бөгөөд үүнд хэлцэл болон ажил гүйлгээний зардлууд орно.

**Бодит үнэ цэнэ** нь хэмжилтийн өдөр зах зээлд оролцогч талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө худалдах, эсвэл хөрөнгө солилцох, өр төлбөр барагдуулахад төлөх үнэ бөгөөд үүний нэгж жишээ нь идэвхитэй зах зээлийн жишиг үнэ юм.

**Хорогдуулсан өртөг** гэдэг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж өгсөн дүн ба санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүнгээр тодорхойлогдоно. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрсөн урамшууллын хойшлогдсон гүйлгээний зардал, мөн хөнгөлөлтийн дүнг үр ашигт хүүний аргаар тооцсон хямдруулалт орно.

**Үр ашигт хүүний арга** гэдэг нь хүүний орлого эсвэл хүүний зардлыг хамаарах хугацааны туршид санхүүгийн хэрэглүүрийн дансны үнээс тооцогдох үр ашигт хүүний хувийг тогтмол байлгахар хуваарилах арга бөгөөд энэхүү хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого болон гарах зарлагыг санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаа эсхүл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж, санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүний хувь болно. Үр ашигт хүүний хувь нь хувьсах хүүтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн мөнгөн урсгалыг хүү өөрчлөгдөх дараагийн мөч хүртэл хорогдуулах бөгөөд санхүүгийн хэрэглүүрд тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүний зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хөнгөлөлт мөн зах зээлийн ханшийн төвшинтэй уялдан өөрчлөхгүй бусад хувьсах хучин зүйлсийн нөлөөг дискаунтчилахгүй.

*Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хэрэглүүр*

Бодит үнэ цэнээр хэмжигддэггүй санхүүгийн хэрэглүүрт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны болон бусад авлага, бусад өглөг багтана. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны болон бусад авлага, бусад өглөг нь богино хугацаат шинж чанартай байдаг тул тэдний дансны үнэ цэнэ нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

*Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл*

*Ерөнхий Зорилго, Бодлого ба Процесс.* Удирдлага нь компанийн эрсдэлийн удирдлагын зорилго, бодлогыг тодорхойлж түүнд үндсэн үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ компанийн санхүүгийн үйл ажиллагааны зорилго, бодлогыг үр

дүнтэйгээр хэрэгжүүлэх процессыг боловсруулж, үйл ажиллагааг нь явуулах эрх мэдэлтэй байдаг.

Компанийн эрсдэлийн удирдлагын үүрэгт санхүүгийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хууль эрх зүйн эрсдэлүүд багтдаг. Санхүүгийн эрсдэл нь зах зээлийн эрсдэл (гадаад валютын эрсдэл, хүүний эрсдэл, болон бусад үнийн эрсдэл), зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын эрсдэлээс бүрдэнэ. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь хүлээх эрсдэлийн хязгаарлалтыг тогтоож, хүлээсэн эрсдэлийн хэмжээг тогтоосон хязгаарлалтаас хэтрүүлэхгүй байлгахад оршино. Үйл ажиллагааны болон эрх зүйн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь, дотоод бодлого, журам, хэвийн үйл ажиллагааг хангах болон үйл ажиллагааны болон хууль эрх зүйн эрсдэлийг багасгах зорилготой.

- i. **Зээлийн эрсдэл.** Санхүүгийн хэрэглүүрийн хувьд нэг тал үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талд санхүүгийн алдагдал учруулахад хүргэх зээлийн эрсдэл компаниудад тулгарч байдаг. Зээлийн эрсдэл нь компани зээлээр борлуулалт хийх болон санхүүгийн хөрөнгө үүсгэх бусад ажил гүйлгээ хийснээр үүсдэг. Компани зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их хэмжээ нь санхүүгийн байдлын тайланд тусгасан санхүүгийн хөрөнгийн дансны үнийн дүн байдаг.

Компанийн санхүүгийн хэлтсээс худалдааны авлагын үлдэгдэлд насжилтын шинжилгээ хийж хяналт тавьдаг бөгөөд хугацаа хэтэрсэн үлдэгдлийг төлүүлэх арга хэмжээ авч ажилладаг. Иймээс зээлийн эрсдэлийн насжилтын болон бусад мэдээллээр хангаж байхыг зохистой гэж удирдлага үздэг.

- ii. **Зах зээлийн эрсдэл.** Хүүтэй, арилжаалагдах болон гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүр хэрэглэснээс үүдэлтэйгээр компани зах зээлийн эрсдэлд өртдөг. Зах зээлийн эрсдэл нь (а) гадаад валют, (б) хүү бодогддог хөрөнгө, өр төлбөр болон (в) өмчийн бүтээгдэхүүний нээлттэй позициос үүсч бий болно. Эдгээр нь бүгд зах зээлийн ерөнхий ба тодорхой шилжилтэд өртдөг.
- iii. **Хүүний төвшний эрсдэл.** Хүүний төвшний эрсдэл гэдэг нь зах зээл дэх зээлийн хүүний төвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм. Мөн компани нь сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг хүүний орлого олох зорилгоор худалдан авагчдад зээлдүүлсэн. Зээлийн хугацаа дуусаж хөрөнгийг эргүүлэн татсан тохиолдолд хүүний орлого буурах магадлалтай.

Уг стандартыг компани хэрэгжүүлж эхлээгүй байна.

- **СТОУС 17 Даатгалын Гэрээ.** 2017 оны 5 дугаар сард хэвлэгдсэн СТОУС 17 нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, танилцуулга ба тодруулгыг хамарсан нягтлан бодох бүртгэлийн шинэ цогц стандарт юм. Хэрэгжиж эхэлмэгц СТОУС 17 нь 2005 онд хэвлэгдсэн СТОУС 4 Даатгалын Гэрээ (СТОУС 4)-г орлоно. СТОУС 17 нь бүх төрлийн даатгалын гэрээ (амь насны, амь насны бус, шууд даатгал, давхар даатгал гэх мэт)-ний хувьд гэрээ хийсэн аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамааран хэрэгжих ба түүнчлэн хэлцэлийн оролцоотой тодорхой баталгаа болон санхүүгийн хэрэгсэлд мөн хамаарна. Уг стандарт 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

#### *Гадаад валютаарх ажил гүйлгээ*

Компанийн тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг юм. Компанийн үйл ажиллагааны үндсэн валют нь Монгол Улсын Төгрөг болно.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах валют болох Төгрөг рүү хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зарлагуудыг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Эдгээр хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

#### *Орлого хүлээн зөвшөөрөлт*

Орлогын үнийн дүнг найдвартай хэмжиж болохуйц бөгөөд компани төлбөр хүлээж авах магадлалтай тохиолдолд үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээ үзүүлсэн үед нь хүлээн зөвшөөрнө.

#### *Өртөг/Зардал хүлээн зөвшөөрөлт*

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.



Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

#### *Санхүүгийн орлого / зардал*

Санхүүгийн орлого, зардалд хүүний орлого (зардал), гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз), санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн олз (гарз) хамаарна. Хүүний орлогыг үр ашигт хүүний аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүний зардлыг үр ашигт хүүний аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

#### *Татварын зардал*

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварын хөрөнгөд хасагдах түр зөрүү болон ашиглагдаагүй татварын алдагдлыг дараагийн үе рүү шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын албан татварын дүн хамаарна.

Аж ахуйн нэгж нь хасагдах түр зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байх тохиолдолд л хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Тайлангийн өдөр бүрээр хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг дахин авч үзнэ. Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөх боломж олгохуйц татвар ногдох ашиг ирээдүйн тайлант үед олох нь тодорхой байгаа үед өмнөх хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хэрэв хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг ашиглах хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалгүй бол тэр хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулна. Энэхүү

бууралтыг хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалтай болсон үед буцаана.

*Ажиллагсадын цалин, тэтгэмж*

- *Ажиллагсадын зардал. Цалин, хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг ажилтны хөдөлмөр эрхэлсэн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Ээлжийн амралт, бусад богино хугацаат тэтгэмжийг олгохоор шийдвэрлэсэн үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.*
- *Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал.* Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухай бүрт нь дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

*Үндсэн хөрөнгө*

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь бүртгэж, хуримтлагдсан элэгдэл болон үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тооцдог. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн тохиолдолд, дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүнгээр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний санд тусгана.

Дуусаагүй капитал ажилд элэгдэл тооцдоггүй. Эдгээр активын элэгдлийг холбогдох активууд ашиглалтанд орсон үеэс тооцож эхэлдэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулахдаа, бүртгэлийн үнэ болон борлуулалтын үнийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч, тухайн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүгийн ашиглагдаагүй хэсгийг хуримтлагдсан ашиг руу шууд хаадаг. Үндсэн хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна.

*Үндсэн хөрөнгийн элэгдэл*

Үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасан хувь хэмжээг үндэслэн тогтоож, орон байшин, эд хогшил, компьютер, машин гэж ангилан дараах ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Үүнд:

Дансны ангилал	Ашиглагдах жил
Барилга, байгууламж	25
Тоног төхөөрөмж	10
Тавилга, эд хогшил	10

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө нь хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг (түүнийг бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд) ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүнг санхүүгийн тайланд тодруулна.

#### *Биет бус хөрөнгө*

Биет бус хөрөнгөнд компьютерийн програм хангамж болон газар эзэмших эрх орно. Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж компанид орж ирэх нь магадлалтай болсон үед биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

#### *Биет бус хөрөнгийн хорогдол*

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг.

Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг ашиг, алдагдлаар биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийн өртгийг дараах тооцоолсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна.

Үүнд:

Дансны ангилал	Ашиглах жил
Патент	10
Програм хангамж	3

*Урьдчилж гарсан зардал ба тооцоо*

Урьдчилж гарсан зардал ба тооцоо нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч дараагийн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрөгдөх төлбөрүүд эсхүл хүлээн аваагүй хөрөнгө (бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө)-ийн төлбөрүүд юм. Үүнийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд ашиг, алдагдлаар, эсвэл хөрөнгийн өртөгт үл хүлээн зөвшөөрч бүртгэдэг Компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг хянадаг.

*Бараа материал*

Үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор эзэмшиж буй түүхий эд, материал, сав баглаа боодол, сэлбэг, хангамжийн зүйлс болон үйлдвэрлэгдсэн бэлэн бүтээгдэхүүнүүд энэ ангилалд хамаарна.

НББОУС 2 *Бараа материал*-д заасны дагуу бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Бараа материалын цэвэр боломжит үнийг тайлант үе бүрийн эцэст тооцно.

Санхүүгийн тайланд бараа материалыг дараах байдлаар тодруулна. Үүнд:

- Түүхий эд материал: үйлдвэрлэлд ашиглагдах үндсэн түүхий эд, туслах материал;
- Хангамжийн материал: аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдах, цаашдаа үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал болох хангамжийн материал, шууд зарцуулагдах багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, шатах тослох материал, бусад хангамжийн шинжтэй зүйлс;
- Бэлэн бүтээгдэхүүн: Үйлдвэрлэгдсэн тэсрэх бодис, хэрэгслэлүүд үүнд хамаарна.

*Санхүүгийн хөрөнгө*

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч компани нь санхүүгийн хөрөнгөө доор дурдсан байдлаар ангилна.

*i. Зээл ба Авлага*

Зээл ба авлага гэсэн ангилалд багтах санхүүгийн хөрөнгө нь идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй үүсмэл бус санхүүгийн хөрөнгө байдаг. Ийм төрлийн санхүүгийн хөрөнгө нь ихэвчлэн харилцагчдад өгсөн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөөцөөр (худалдааны авлага) дамжиж үүсэх бөгөөд мөн бусад төрлийн гэрээгээр хүлээсэн мөнгөөрх хөрөнгөөс бүрддэг байна. Зээл ба авлагыг бодит үнэ цэнэ дээр нь худалдан авалттай шууд хамааралтай ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрөх ба дараа үеүдэд үр ашигт хүүний төвшин ашиглан хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ.

Компани авлагаа бүгдийг нь цуглуулж чадахгүй гэсэн бодит нотолгоотой (харилцагч санхүүгийн хүндрэлд орох, дампуурах, урт хугацаагаар хойшлуулах) бол үнэ цэнийн бууралтын нөөц үүсгэх ба тухайн нөөцийн үнийн дүнг үнэ цэнийн бууралт үүсгэж буй авлагын дансны цэвэр үнэ болон ирээдүйн таамагласан мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр тооцно. Цэвэр дүнгээр тайлагнагддаг худалдааны авлагын үнэ цэнийн бууралтыг тусад нь нөөцийн данс үүсгэж, гарзыг нь ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн удирдлагын зардалд тусгана.

Компанийн зээл ба авлага нь санхүүгийн байдлын тайлан дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон худалдааны болон бусад авлагаас бүрддэг.

*ii. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө*

Касс болон харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэл хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

*Санхүүгийн өр төлбөр*

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг. Хөйджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрийг компани нь дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын дагуу ангилна:

*i. Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Компани ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах (хейдж) зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд компанид арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

*ii. Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*

Компанийн хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт худалдааны болон бусад өр төлбөр, банкны зээл, хувьцаанд хөрвөх зээлийн өглөг зэрэг хамаарна. Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр үнэлж хэмжинэ.

*Хувьцаат капитал*

Хувьцаат капитал нь компанийн гаргасан хувьцааг илэрхийлэх бөгөөд хүлээн авсан дүнгээс хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр хэмжигддэг.

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүдийг өмчөөр ангилж бүртгэнэ.

Бүх өр төлбөрийг хассаны дараа хөрөнгөөс үлдэх хувь оролцоог нотлох аливаа хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэнэ.

#### 4. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Түрээсийн орлого	4,122,721.2	3,672,469.6
Бараа бүтээгдхүүн борлуулсны орлого	18,181.8	-
<b>Нийт борлуулалтын дүн</b>	<b>4,140,903.0</b>	<b>3,672,469.6</b>
Борлуулалтын хорогдол ба буцаалт	-	-
<b>Цэвэр борлуулалтын дүн</b>	<b>4,140,903.0</b>	<b>3,672,469.6</b>

Түрээсийн орлого өмнөх оноос 11.3 хувиар буюу 468,433.4 мянган төгрөгөөр буурсан.

#### 5. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Борлуулсан барааны өртөг	-	-
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 6. БУСАД ОРЛОГО

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Хүүний орлого	292,660.6	73,408.7
Бусад орлого	32,385.9	2,428.6
<b>Нийт дүн</b>	<b>325,046.5</b>	<b>75,837.3</b>

Хүүний орлого 219,251.9 мянган төгрөгөөр буюу 74.9 хувиар буурсан байна.

#### 7. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Ажилчдын цалингийн зардал	436,661.2	492,349.1
НДШ-ийн зардал	54,564.4	25,417.2
Албан татвар, төлбөр хураамж	126,985.9	121,477.2
Албан томилолтын зардал	45,598.8	-
Бичиг хэргийн зардал	1,847.8	2,714.9
Шуудан холбооны зардал	8,659.9	9,173.4
Мэргэжлийн үйлчилгээний зардал	86,539.0	82,331.7

**“ГУТАЛ” ХК-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Сургалтын зардал	25.0	650.0
Сонин сэтгүүл захиалгын зардал	-	4.9
Даатгалын зардал	295.8	-
Ашиглалтын зардал	520,053.3	487,024.0
Засварын зардал	87,626.8	212,419.6
Элэгдлийн зардал	268,096.3	418,888.0
Харуул, хамгаалалтын зардал	1,190.4	-
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	4,342.4	7,199.8
Тээврийн зардал	22.0	-
Шатахууны зардал	14,332.5	12,482.0
Зар сурталчилгааны зардал	1,737.8	1,635.2
Бусад зардал	24,545.4	162,532.5
<b>Нийт дүн</b>	<b>1,683,124.7</b>	<b>2,036,299.5</b>

*Тайлант жилд ажилчдын цалингийн зардал 12.7 хувиар, элэгдэлийн зардал 99.8 хувиар, цэвэрлэгээ үйлчилгээний зардал 65.8 хувиар, бусад зардал 178.4 хувиар, засварын зардал 70.2 хувиар тус тус өсч харин ашиглалтын зардал 6.3 хувиар, шатахууны зардал 9.1 хувиар тус тус буурсан байна.*

**8. БУСАД ОЛЗ, ГАРЗ**

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Бусад орлого	32,385.9	2,428.6
Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз/гарз	14,107.3	67,849.6
<b>Нийт дүн</b>	<b>46,493.2</b>	<b>70,278.2</b>

**9. БУСАД ЗАРДАЛ**

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Алданги торгуулийн зардал	132.7	1,316.0
Хандив тусламжийн зардал	1,000.0	-
Бусад зардал	109,643.7	6,099.1
<b>Нийт дүн</b>	<b>110,776.4</b>	<b>7,415.1</b>



10. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

2020 онд компани нь Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу тайлант жилийн 3 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах орлогоос 10 хувиар, 3 тэрбум төгрөгөөс дээших татвар ногдуулах орлогын дүнд 25 хувиар орлогын албан татвар ногдуулж, төлөх үүрэгтэй.

	2020 он мян.төг
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>1,772,434.3</b>
<i>Байнгын зөрүү</i>	
- Татвараас хасагдахгүй зардал /Алданги/	119,868.4
- Харилцах дансны хүүний орлого	73,408.7
<b>Байнгын зөрүүгээр зохицуулагдсан дүн</b>	<b>1,818,894.0</b>
<b>Татварын зардал</b>	<b>0.0</b>
<i>Түр зөрүү</i>	
- Валютин ханшийн бодит бус ашиг	64,860.7
- Валютин ханшийн бодит бус алдагдал	-
<b>Татвар ногдох орлого</b>	<b>1,754,033.3</b>
- Шилжүүлэх алдагдлын дүн	
<b>Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлого</b>	<b>1,754,033.0</b>
- <b>Ногдуулсан татвар</b>	<b>175,403.3</b>
Түрээсийн төлбөрийг буруулсан аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлсөн дүн	175,403.3
<b>Тусгайлсан хувь хэмжээгээр татвар ногдох орлого</b>	<b>73,408.7</b>
- Татварын хувь	10
- Ногдуулсан татвар	7,340.8
<b>Орлогын татварын Өглөг</b>	
Хойшлогдсон татварын хөрөнгө	
<b>Орлогын албан татварын зардал</b>	<b>7,340.8</b>

**11. БИЕТ ХӨРӨНГӨ**

	Газрын сайжруулалт	Барилга байгууламж	Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
<b>Эртгэг/ дахин үнэлгээний дүн</b>							
0 оны 01-р сарын 01-нээр эзгдсэн	5,204.5	8,768,720.0	348,228.0	119,788.9	141,690.2	7,606.7	9,386,033.8
ин үнэлгээ		7,865,781.2			1,633.5	2,031.5	7,874,650.7
агдсан		8,416,464.6					8,416,464.6
ируулга*							
0 оны 12 дугаар сарын 31-нээр	<b>5,204.5</b>	<b>8,218,036.7</b>	<b>348,228.0</b>	<b>119,788.9</b>	<b>143,323.7</b>	<b>9,638.2</b>	<b>8,844,220.0</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>							
0 оны 01-р сарын 01-нээр		883,652.1	176,343.0	76,685.7	117,427.3	1,416.7	1,255,524.9
лант жилд байгуулсан		351,037.9	30,737.8	12,113.0	21,656.4	2,901.8	418,446.8
ин үнэлгээгээр нэмэгдсэн		773,334.4					773,334.4
знаас хассан		<b>461,355.6</b>	<b>207,080.7</b>	<b>88,798.7</b>	<b>139,083.7</b>	<b>4,318.5</b>	<b>900,637.2</b>
0 оны 12 дугаар сарын 31-нээр	<b>5,204.5</b>	<b>7,756,681.0</b>	<b>141,147.3</b>	<b>30,990.2</b>	<b>4,240.0</b>	<b>5,319.7</b>	<b>7,943,582.8</b>
<b>Дансны цэвэр дүн</b>							

## 12. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Өртөг/ дахин үнэлгээний дүн	Програм хангамж	Нийт
	мян.төг	мян.төг
2020 оны 01-р сарын 01-нээр	-	-
Нэмэгдсэн	1,320.0	1,320.0
Хасагдсан	-	-
2020 оны 12 дугаар сарын 31-нээр	<b>1,320.0</b>	<b>1,320.0</b>
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>		
2020 оны 01-р сарын 01-нээр	341.2	341.2
Тайлант жилд байгуулсан	441.2	441.2
Данснаас хассан	-	-
2020 оны 12 дугаар сарын 31-нээр	782.4	782.4
<b>Дансны цэвэр дүн</b>	<b>537.6</b>	<b>537.6</b>

Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй програм хангамжийг ашиглагдах хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулан орлогын тайланд тусгадаг.

## 13. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2019.12.31		2020.12.31	
	Хөрөнгө оруулалтын хувь	/мян.төг/	Хөрөнгө оруулалтын хувь	/мян.төг/
Мон ИТ Булираар ХК	1.6%	25,216.6	1.6%	25,216.6
Саксон Монголиа ХХК	50%	-	50%	-
<b>Нийт дүн</b>		<b>25,216.6</b>		<b>25,216.6</b>

## 14. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ

	2019.12.31	2020.12.31
	/мян.төг/	/мян.төг/
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	353,304.2
<b>Нийт дүн</b>	-	<b>353,304.2</b>

### 15. БАРАА МАТЕРИАЛ

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Түүхий эд материал	-	-
Хангамжийн материал	114,355.9	112,976.4
<b>Нийт дүн</b>	<b>114,355.9</b>	<b>112,976.4</b>

### 16. ДАНСНЫ АВЛАГА

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Түрээслэгчдээс авах авлага	426,423.3	805,492.0
<b>Нийт дүн</b>	<b>426,423.3</b>	<b>805,492.0</b>

“Гутал” ХК-ийн дансны авлага нь түрээслэгчдээс авах авлагтай холбоотойгоор үүсдэг бөгөөд тайлант хугацаанд дансны авлагын хэмжээг 88.8 хувиар өссөн байна.

### 17. БУСАД АВЛАГА

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
НДШ-ийн авлага	5,064.1	5,265.9
ХХОАТ суутган авлага	7,380.2	-
ААНОАТ-ын авлага	-	35,540.3
Ажилчдаас авах авлага	2,128,552.7	1,416,947.1
Хүүний авлага	6,794.1	-
Бусад талуудаас авах авлага	2,739.2	3,125.4
<b>Нийт дүн</b>	<b>2,150,530.3</b>	<b>1,460,878.7</b>

## 18. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Хугацаатай, хүүтэй хадгаламжийн сертификат	1,476,100.6	1,424,945.0
<b>Нийт дүн</b>	<b>1,476,100.6</b>	<b>1,424,945.0</b>

“Гутал” ХК нь жил бүрийн ашгаас нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараадаг бөгөөд тухайн ногдол ашгийг цаг тухай бүрт нь олгох зорилгоор тодорхой мөнгөн хөрөнгийг хугацаатай хадгаламжид байршуулдаг байна.

## 19. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Бэлэн мөнгө	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Касс дахь бэлэн мөнгө		
Төгрөг	1,585.6	4,586.4
Банкинд байгаа мөнгө		
Төгрөг	706,551.6	636,878.8
Ам доллар /USD/	475.7	143.1
<b>Нийт дүн</b>	<b>708,612.9</b>	<b>641,608.3</b>

Банкинд байгаа мөнгө	2019.12.31 /мян.төг/	2020.12.31 /мян.төг/
Хаан банк		
Төгрөг	687,521.2	630,864.6
Доллар	475.7	143.1
Хас банк		
Төгрөг	19,030.4	6,014.1
<b>Нийт дүн</b>	<b>707,027.3</b>	<b>637,021.8</b>

“Гутал” ХК нь мөнгөн хөрөнгийн зарцуулалтын журамтай бөгөөд бэлэн мөнгөөр хийгдэх гүйлгээний зөвшөөрлийг ерөнхий захирал Б.Төмөр, нягтлан бодогч Л.Өнөрсайхан нар гарын үсэг зурж төлбөр тооцоог гүйцэтгэдэг байна. Санхүүгийн тайлангийн аудитын банкны тулган баталгаажуулалтаар Хаан банкин дахь 5122010639, Хас банкин дахь 5000075927, 5001064466 тоот дансууд буурсан болно.

**20. ЭЗНИЙ ӨМЧ**

	<b>2019.12.31</b>	<b>2020.12.31</b>
	<b>/мян.төг/</b>	<b>/мян.төг/</b>
Хувийн өмч	161,868.4	161,868.4
Халаасны хувьцаа	(13,823.9)	(13,823.9)
Нэмж төлөгдсөн капитал	90,744.7	90,744.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,364,780.0	8,364,780.0
Эздийн өмчийн бусад хэсэг	1,369.0	332,153.0
Хуримтлагдсан ашиг	3,645,411.6	3,016,694.7
<b>Нийт дүн</b>	<b>12,250,349.8</b>	<b>11,952,417.0</b>

**21. БУСАД ӨГЛӨГ**

	<b>2019.12.31</b>	<b>2020.12.31</b>
	<b>/мян.төг/</b>	<b>/мян.төг/</b>
Ногдол ашгийн өглөг	555,905.7	646,083.4
<b>Бусад өглөгийн дүн</b>	<b>555,905.7</b>	<b>646,083.4</b>

**22. ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ**

	<b>2019.12.31</b>	<b>2020.12.31</b>
	<b>/мян.төг/</b>	<b>/мян.төг/</b>
ААНОАТ-ын өглөг	75,163.3	-
НӨАТ-ын өглөг	40,761.7	27,091.2
ХХОАТ-ын өглөг	6,924.2	5,506.5
ҮХЭХАТ өглөг	2,458.7	2,458.7
<b>Нийт дүн</b>	<b>125,307.9</b>	<b>35,056.4</b>

**23. БОЛЗОШГҮЙ АЛДАГДАЛ БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА**

Болзошгүй алдагдал ба үүрэг хариуцлага нь компанийн бүрэн хяналтаас гадуурх ирээдүйд тохиолдох болон үл тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгадаггүй. Компани болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй боловч Нортланд фаншин хаус ХХК-аас авах 157,687.9, Ворлд органик фүүдс ХХК-аас авах 63,731.7 нийт 221,419.6 мянган төгрөгийн авлага шүүхийн шатанд шийдвэр гарсан боловч алдагдал хүлээж болзошгүй хэвээр байна.